



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 38

Мандалговь

**Үндсэн хөрөнгө бүртгэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэст шаардлагатай нийт 5,250,000 /таван сая хоёр зуун тавин мянга/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга (Б.Энхтуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 2 дугаар сарын  
22-ний өдрийн 28 тогтоолын хавсралт

Статистикийн хэлтэст үндсэн хөрөнгө бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Notebook	ш	1	2,600,000.00	2,600,000.00
2	Зургийн аппарат	ш	1	1,100,000.00	1,100,000.00
3	Цаас зүсэгч	ш	1	300,000.00	300,000.00
4	Ширээ	ш	1	280,000.00	280,000.00
5	Хурлын ширээ	ш	1	250,000.00	250,000.00
6	Шкаф	ш	1	320,000.00	320,000.00
7	Шүүгээ	ш	1	120,000.00	120,000.00
8	Принтер	ш	1	280,000.00	280,000.00
<b>Нийт дүн</b>				<b>5,250,000</b> /таван сая хоёр зуун тавин мянган/ төгрөг	<b>5,250,000</b> /таван сая хоёр зуун тавин мянган/ төгрөг